



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 сны 10 сарын 10 өдөр

Дугаар 4/387

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Агаарын тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 12 дугаар зүйлийн 12.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Агаарын чанарын индексээр агаарын чанарыг үнэлэх, мэдээлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг авч ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Нямдаваа/, Цаг уур, орчны шинжилгээний газар /С.Энхтувшин/-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам, аргачлал батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А-327 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэ тушаалыг 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
A/387... дугаар тушаалын хавсралт

АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКСЭЭР АГААРЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-ын зорилго нь Агаарын тухай хууль, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2016 стандартад нийцүүлэн агаарын чанарын мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэхэд оршино.

1.2. Агаарын чанарын индекс гэж хот, суурин газрын хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг тухайн бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд нөлөөлөх агууламжийн утгатай харьцуулсан тоон үзүүлэлтийг хэлнэ.

1.3. Агаарын чанарыг индексээр үнэлж, мэдээлэх нь хот, суурин газрын хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, мэдээлэх, агаарын бохирдоос хамгаалах талаар олон нийтэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, агаарын бохирдоос сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг болно.

1.4. Агаарын чанарын индексийг тухайн агаарын чанарын хяналтын харуулын хяналт шинжилгээний хөтөлбөрийг харгалzan агаар дахь түгээмэл тархалттай 3-аас доошгүй үндсэн бохирдуулах бодисоор тооцно. Үүнд:

- а) хүхрийн давхар исэл (SO_2);
- б) азотын давхар исэл (NO_2);
- в) PM10 тоосонцор эсхүл PM2.5 тоосонцор;
- г) нүүрстөрөгчийн дутуу исэл (CO);
- д) озон (O_3)

Хоёр. Агаарын чанарын индексийн ангилал ба үнэлгээ

2.1. Агаарын чанарыг Агаарын чанарын индексээр 6 түвшинд ангилах бөгөөд түвшин тус бүрт харгалзах индексийн тоон үзүүлэлт, өнгөт тэмдэглэгээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Агаарын чанарын индекс, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Тэмдэглэгээ (өнгөөр)	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0 - 50	Цэвэр	Ногоон	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй.
51-100	Хэвийн	Шар	Агаарын чанарын стандартын шаардлага хангана. Гэхдээ зарим хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101 – 200	Бага бохирдолтой	Улбар шар	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
201 – 300	Бохирдолтой	Улаан	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
301- 400	Их бохирдолтой	Ягаан	Удаан хугацаагаар гадаа байхад хүний эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл үзүүлж болно.
401-500	Маш их бохирдолтой	Хүрэн	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.

2.2. Агаарын чанарын индекс нь 100 ба түүнээс бага байвал агаарын чанар стандартын шаардлага хангаж байна гэж 101-ээс их байвал агаар бохирдож стандартын шаардлага хангахгүй байна гэж үзнэ.

Гурав. Агаарын чанарын индексийг тооцоолох арга

3.1. Агаарын чанарын индексийг тооцоходоо энэ журмын 1.4-д заасан агаар дахь бохирдуулах бодис тус бүрээр дараах томъёог ашиглан тооцоолно.

$$A\bar{C}I_i = \frac{A\bar{C}I_i \text{ дээд} - A\bar{C}I_i \text{ доод}}{TXA \text{ дээд} - TXA \text{ доод}} (Ci - TXA \text{ доод}) + A\bar{C}I_i \text{ доод}.$$

$A\bar{C}I_i$ - i бохирдуулах бодисын агаарын чанарын индекс

C_i - агаар дахь i бохирдуулах бодисын агууламж

$TXA_{\text{дээд}}$ - i бохирдуулах бодисын агууламжид хамаарах хязгаарын дээд утга

$TXA_{\text{доод}}$ - i бохирдуулах бодисын агууламжид хамаарах хязгаарын доод утга

АЧИ_{дээд} - ТХА_{дээд}-д харгалзах агаарын чанарын индекс

АЧИ_{доод} - ТХА_{доод}-д харгалзах агаарын чанарын индекс

3.2. Бохирдуулах бодис тус бүрийн 1 болон 24 цагийн дундаж агууламжид хамаарах хүний эрүүл мэндэд нөлөөлөх хязгаарын дээд, доод утгыг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Агаарын чанарын индексэд харгалзах хязгаарын утгууд

Агаарын чанарын индекс	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх агууламжийн хязгаарын утга /Breakpoint/									
	SO ₂ , мкг/м ³ /24 цаг/	SO ₂ , мкг/м ³ /1 цаг/	NO ₂ , мкг/м ³ /24 цаг/	NO ₂ , мкг/м ³ /1 цаг/	PM10, мкг/м ³ /24 цаг/	PM2.5, мкг/м ³ /24 цаг/	CO, мг/м ³ /8цаг/	CO, мг/м ³ /1цаг/	O ₃ , мкг/м ³ /8цаг/	O ₃ , мкг/м ³ /1цаг/
0-50	-	0-100	-	0-100	0-50	0-35	0-5	-	0-50	-
51-100	-	101-300	-	101-200	51-100	36-50	5-10	11-30	51-100	-
101-200	50-800	301-800	50-280	201-700	101-300	51-150	11-15	31-60	101-265	250-400
201-300	801-1600	801-1600	281-565	701-2000	301-420	151-250	16-30	61-90	266-800	401-800
301-400	1601-2100	1601-2100	566-750	2001-3500	421-500	251-350	31-40	91-120	-	801-1000
401-500	2101-2620	2101-2620	751-940	3501-3840	501-600, 601<	351-500, 501<	40-50	120-150	-	1001-1200

3.3. Бохирдуулах бодис тус бүрээр тооцсон индексийн хамгийн өндөр тоон утгыг тухайн үеийн агаарын чанарын индекс гэж тогтооно. Жишээлбэл: Агаарын чанарын индексээр тооцоолоход хүхрийн давхар ислийн индекс 110, азотын давхар ислийн индекс 95, PM10 тоосонцор 150 гэж байвал тухайн үеийн агаарын чанарын индексийн ерөнхий үзүүлэлтийг 150 гэж үнэлж, агаарын чанар бага зэргийн бохирдолтой тувшинд хүрсэн байна гэж үзнэ.

Дөрөв. Агаарын чанарын индексийн мэдээлэл

4.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний байгууллага, мэргэжлийн алба, орон нутаг дахь хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын чанарын индексийн мэдээг холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлэх байдлыг хариуцна.

4.2. Агаарын чанарын индексийн мэдээг цаг хугацааны хувьд дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:

а) тухайн үеийн (PM2.5, PM10 тоосонцрын агууламжийг сүүлийн 3 цаг, хүхрийн давхар исэл (SO₂), азотын давхар исэл (NO₂)-ийн агууламжийг сүүлийн 1 цаг, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) агууламжийг сүүлийн 8 цагаар дундажилж тус тус тооцоолно. Жич: Хүхэрлэг хийн агууламж нэг цагийн дундаж агууламж 301 мкг/м³-ээс, азотын давхар ислийн нэг цагийн дундаж агууламж 201 мкг/м³-ээс их бол хоногийн индексээр, озоны 1 цагийн дундаж агууламж 250 мкг/м³ хүрсэн үед 8 цагийн индексээр тус тус шилжүүлж тооцоолно.)

б) өмнөх үеийн.

4.3. Агаарын чанарын индексийн мэдээнд дараах мэдээллийг багтаана.

Үүнд:

- а) байршил;
- б) хугацаа (он, сар, өдөр, цаг);
- в) индексийн хамгийн өндөр үнэлэгдсэн гол бохирдуулах бодисын нэр болон индексийн тоон үзүүлэлт;
- г) агаарын чанарын индексийн ангилалд харгалзах агаарын чанарын түвшин, тэмдэглэгээ (өнгөөр);
- д) эрүүл мэндийн нөлөөлөл;

4.4. Агаарын чанарын индексийн мэдээг хураангуй эсвэл дэлгэрэнгүй хэлбэрээр, хэвлэл мэдээллийн дараах хэрэгслээр мэдээлнэ. Үүнд:

- а) цахим хуудас;
- б) телевиз;
- в) гар утасны аппликашн;
- г) бусад;

Байгаль орчин, аялал жуулчлалын яам